

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 19-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Соёлын өвийн төвийн захиралтай 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Үр дүнгийн гэрээ, Соёлын өвийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөны дагуу 2013 онд хийгдсэн ажлыг тайлагнаж байна.

НЭГ. Байгууллага (Соёлын биет өвийг хамгаалах хэлтэс)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

1.1 Төв аймгийн баруун талын сумдын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах

Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо, суврага зэргийг бүртгэх тоолох” ажил, Монгол Улсын засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолоор “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр” зэрэг ажлуудыг нэгтгэн зохион байгуулж 2008 оноос эхлэн аймгуудын үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн, тоолох ажлыг хийж ирсэн билээ.

Тус ажлын хүрээнд Төв аймгийн Баянцогт, Аргалант Баянхангай, Лүн, Эрдэнэсант, Бүрэн сумын нутагт 2013 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 30-ны өдрүүдэд ажиллаж тус сумдын нутаг дэвсгэр дэх үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгааны багт үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн археологч Г.Анхсанаа, археологч Т.Эрдэнэцогт, техник хариуцсан ажилтан Ч.Чинбат, Төв аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Н.Мягмар, тус музейн бүртгэл-мэдээллийн ажилтан Г.Дагмидмаа, Соёлын өвийн төвийн жолооч н.Эрдэнэчимэг нар ажиллав.

Судалгааны баг нэр дурдсан 5 сумын нутагт нийт 1773 км явж нийт 35 дурсгалыг давтан болон шинээр илрүүлэн бүртгэж тэдгээрийг 4000 орчим дижитал эх үүсвэрийн гэрэл зураг, 50 орчим хальсны эх үүсвэрийн гэрэл зураг, 2 гар зураг 20 минутын дүрс бичлэгээр тус баримтжуулан хийж гүйцэтгэлээ. Дэлгэрэнгүй тайланг Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн УНБМСангийн архивт хадгалав.

1.2 Завхан аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалт.

Соёлын өвийн төв, завхан аймгийн музейн төлөөлөл оролцсон баг 2013 оны 6 дугаар сарын 9-нөөс 8 дугаар сарын 10-ны хооронд 60 хоногийн хугацаанд Завхан аймгийн 24 сумын нутагт байгаа 320 гаруй дурсгалт газар орших түүх соёлын үл хөдлөх дурсгалыг 10000 гаруй км туулан анхан шатны товч тодорхойлолт хийж, гар болон гэрэл зураг, дүрс бичилгээр давтан болон шинээр бүртгэн баримтжуулж авлаа.

Энэ удаагийн бүртгэн баримтжуулах ажлын явцад 20 гаруй буган чулуун хөшөө, 40 орчим хүн чулуун хөшөө, 30 орчим хадны зургийг шинээр олж илэрүүлэн нь онцлог байв.

Нийт давхартсан тоогоор 21000 кадр буюу 170 GB гэрэл зураг, 216 хальс, 120 орчим минутын HD форматын бичлэг, 24 ш гар зураг зурж авлаа.

Одоо дээрхи мэдээлэлийг улсын нэгдсэн бүртгэл мэдээлэлийн санд цэгцлэн байршуулах дэлгэрэнгүй тайлаг бичиж байна.

1.3 Рашаан хадны дурсгалыг 3 хэмжээст технологиор бүртгэн баримтжуулж, сурталчлах

Рашаан хадны дурсгалыг бүрэн хэмжээгээр 3D-ээр сканнердаж баримтжуулах судалгааны ажлыг тус төвийн програмист Б.Алтансүх, туслах програмист Ж.Даваацэрэн, менежер С.Бундхорол, Японы судлаач Ямагучи Хироши, Абей Рай нарын бүрэлдэхүүнтэй баг 2013 оны 8-р сарын 8-16-ны хооронд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажилд FARO FOCUS 3D, Vivid 9i зэрэг 3D лазер сканнер ашиглан хэмжилт хийж мэдээлэл цуглуулсан бөгөөд мэдээллийг боловсруулан дурсгалыг танилцуулсан төрөлжсөн веб хуудсыг 2014 онд хийхээр төлөвлөж байна. Энэ ажил нь “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд аялал жуулчлалын бүс, чиглэлд буй дурсгалт газрыг сурталчлах ажлын хүрээнд хийгдэж буй онцлог ажил болно. Дэлгэрэнгүй тайланг Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн УНБМсанд хадгалав.

1.4. Суман голын хавцлын хадны зургийг баримтжуулах судалгаа

2013 оны 8 дугаар сард 14 хоногийн хугацаатай Архангай аймгийн Тариат сумын нутаг орших Суман голын дурсгалт газар судалгааны ажил хийхээр төлөвлөсөн боловч, ажлын ачааллаас шалтгаалан хийгдэж чадаагүй болно.

1.5. Дэл уулын дурсгалыг бүртгэн баримтжуулах

Анх 2011 онд Дэл уулын орчимд ажилласан Соёлын өвийн төвийн бүртгэл судалгааны баг тус газарт оршин буй хадны сүг зураг, бичээс, сүм хийдийн туйрь гэх мэт Дэл уулан дах түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын орчинд дүн шинжилгээ хийж нэн даруй хамгаалах нь зүйтэй гэж үзсэн билээ.

2012 оны 7 дугаар сарын 16-наас 7 дугаар сарын 23-ныг хүртэлх хугацаанд энэ ажилд шаардагдах хүн хүч, цаг хугацаа, төсөв хөрөнгө, хийгдэх ажлыг оновчтой зөв төлөвлөх, судалгааны ажлыг хэрэгжүүлэх арга зүйг газар дээр нь судлах зорилгоор Соёлын өвийн төв, Дундговь аймгийн музейн хамтарсан баг Дэл уулын орчимд туршиц судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн юм.

Дээрхи ажлын дүр дүнд бид Дэл уулын Өлзийтийн хуудас, баруун Билүүний орчимд 5000 орчим га газар явганаар самналт хайгуул хийж 30 орчим цэгт хадны зургийн шинэ дурсгалыг илрүүлэн тэдгээрийн байршилыг GPS-ээр тогтоож, 1500 орчим гэрэл зургаар баримтжуулсан болно. Мөн төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уран сайхны кино, гэрэл зургийн цомог, интэрнэтэд байршуулах 3 D технологи бүхий авто понарамм зэргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг хуримтлуулсан байна. Судалгааны баг дурдан буй ажлуудыг төвлөрүүлэн хийх газрыг 3 цэгт зохион байгуулах нь зүйтэй хэмээн үзсэн билээ.

2013 онд бид өмнө жил гаргасан төлөвлөгөөний дагуу хадны зургийн нягтрал ихтэй гэж үзсэн Баруун, Зүүн билүүн, Өлзийтийн хуудас гэсэн газруудад ажиллах, 2012 оны хайгуулиар илрүүлж олж чадаагүй дурсгалуудыг олж илрүүлэн баримтжуулах болон Дэл уул орчимын бичгийн дурсгалуудаас хэв дардас авах үндсэн зорилготой 14 хоногийн хугацаатай ажиллаа. Энэ хугацаанд:

- Булаг билүүний арын хаданд орших 4 хэсэг руни бичээс болон түүнээс баруун хойд зүгт орших хадны зургуудаас зарим өвөрмөц дүрслэл, өгүүлэмж бүхий хадны зургаас дардас авж, гэрэл зургаар баримтжуулан, солбицлыг тогтоов.
- Жирмийн худгийн ойролцоо орших сүүлд олдсон 1 руни бичгийн дардас авж, гэрэл зургаар баримтжуулан, солбицлыг тогтоов.
- Өлзийтийн хуудсанд орших “32 хүн хөшөөт” хэмээх дөрвөлжин булшны хашлага дээрхи зургуудаас дардас аваад, түүний гар зургийг хийж, гэрэл зураг авлаа.
- Зүүн билүүний худгийн орчимд байрлах эртний хятад бичээс болон түүний хойно байгаа монгол бичиг, нарийн зураасаар дүрсэлсэн морьтнууд, янгирын дүрснээс дардас авч, бичлэгээр баримтжуулав.

- Өлзийтийн хуудасны орчимд нэг бичээс байгаа гэсэн (байгаль хамгаалагч Б.Бадрах үзсэн бөгөөд түүний хэлж байгаагаар Монгол бичиг байсан бололтой юм) сургаар хайгуул хийсэн боловч олсонгүй.
- Өлзийтийн хуудасны орчим байх 2 тэрэгний зургаас дардас авж, гэрэл зургийг авч, солбицлыг тогтоов.

Бид монгол, луни, хятад 3 хэлийн 8 хэсэг бичээс болон хадны зургийн 30 орчим дардас, 1200 орчим гэрэл зураг, 20 минутын бичлэг, “32 хүн хөшөөт” хэмээх дөрвөлжин булшны гар зургийг хийж бүх дурсгалуудын GPS-ээр солбицлыг тогтоон тэмдэглэж улсын нэгдсэн бүртгэл мэдээлэлийн санд байршуулав.

1.6. Монголын Бурханы шашинтны Төв Гандантэгчинлэн хийдийн бурхан шашны холбогдолтой, түүх, соёлын дурсгалд тооцогдох эд өлгийн зүйлийн тооллого явуулах, бүртгэн баримтжуулах

ССАЖ-ын Сайдын 2012 оны А/117 тоот тушаалын дагуу Монголын Бурханы шашны Төв Гандантэгчэнлин хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн улсын тооллогыг 2013 оны 4 дүгээр сарын 16-наас эхлэн явуулж байна. МБШТ Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын дурсгалууд бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн улсын тооллого хамгийн сүүлд 1987 онд хийгдсэнээс хойш 26 жилийн дараа улсын тооллого хийгдэж байгаа юм.

Соёлын өвийн төв нь тус хийдэд улсын тооллого явуулахад түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх мэргэжил арга зүйгээр ханган, тооллогын ажлыг удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Тус хийдэд улсын тооллого явуулах бэлтгэл ажлын хүрээнд:

- Улсын тооллогын удирдамж болон шаардагдах төсвийг боловсруулах,
- Хийдийн шүтээн эд зүйлсийн ерөнхий бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийг боловсруулах, зохиох,
- Тооллогын ерөнхий бүртгэлийн дэвтрийг хэвлүүлэх зэрэг бэлтгэл ажлуудыг 2013 оны эхний 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэлээ.
- Гандантэгчэнлийн хийдийн Улсын тооллогын комиссын гишүүдэд зориулан “Улсын тооллого явуулах тухай” сургалтыг 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, гарын авлага материалыг хэвлэн, хангав.

1987 онд явагдсан улсын тооллогоор Гандантэгчэнлин хийдэд нийтдээ **4915** дэсийн **20213** дурсгал тоологдсон байна.

Тооллого эхэлсэн 2013 оны 4 дүгээр сарын 16-наас хойш 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар тус хийдийн “Номын сангийн урд склад”, “Номын сан”,

“Их гэр”, “Дэдон поврон”, “Жасын доод давхар”, “Гандан дуган”, “Дашчоймпэл дацан”, “Идгаа чойнзинлин”, “Жанрайсиг”, “Гал зуух”, “Гандан лаврин”, “Дүйнхор дацан”, “Гунгаачойлин” зэрэг 13 дуган, дацангуудад хадгалагдаж байгаа нийдээ **3970** дэсийн **13600 ш** бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийг тоолж, бүртгээд байна.

Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогыг тус хийдийн лам нараас гадна Соёлын өвийн төв, Байгалийн түүхийн музей, Үлэг гүрвэлийн төв музейн ажилтнуудаас бүрдсэн тооллогын комисс хийж байна. Тооллогод ажиллаж байгаа музейн ажилтан тус бүртэй “Хариуцлагын гэрээ” байгуулан ажиллаж байна.

Тооллогын ажил нь дараах ажлын дараалалтай явагдаж байгаа ба шинээр сан хөмрөгт орох, гүнгэрваа нээх онгойлгох үеийн видео бичлэгийг хийж байгаа болно.

1-рт: Бурхан шүтээн, эд өлгий зүйлсийг нэг бүрчлэн цэвэрлэх, тоос шорооноос нь салгах, хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулах арга хэмжээ авч буй талаар:

Сүм дуган дахь сан хөмрөг, гүнгэрваа нь олон жил нээгээгүй, хүний гар хүрээгүйгээс шороо тоос ихээр хуримтлагдсан, тортог ихтэй байна. Тооллогын явцад склад, сан хөмрөгийн өрөө болон гүнгэрваанаас гарч байгаа бурхан, шүтээн бүрийг нэгбүрчлэн шороо тоосноос салгах цэвэрлэх ажил хийгдэж байна. Цэвэрлэгээний ажилд тоос сорогч, зөөлөн даавуу, хөвөн, бийр багс зэргийг ашиглаж байгаа.

Соёлын өвийн төвийн Сэргээн засварлах хэлтсийн мэргэжилтэнгүүдийн өгсөн дурсгалд хуурай цэвэрлэгээ хийх арга зүйн зөвлөмжийн дагуу дурсгалуудыг цэвэрлэх арчлан тордох ажлуудыг хийж байна.

2-рт: Бурхан шүтээн, эд өлгий зүйлсийг нэг бүрчлэн нүдээр үзэж, бүртгэн тоолж, 1987 оны бүртгэлийг шинэчлэн сайжруулж бүртгэлийг гараар бичиж хөтөлж буй талаар:

Энэхүү тооллогоор 1987 оны бүртгэлийг шинэчлэн бүртгэхдээ гараар бичиж байгаа ба дурсгал нэг бүрийг биечлэн үзэж, шинээр дугаар өгч бүртгэн тоолж байна. Ерөнхий бүртгэлд 1987 оны бүртгэлийг баримтлан бүртгэж байгаагаас гадна 2005, 2009, 2011 онуудад тус хийдийн өөрсдийн хийсэн тооллогын бүртгэлүүдийг ашиглаж байгаа. Гэвч дээрх онуудын бүртгэлд тухайн дурсгалын талаарх мэдээлэл хомс тусгагдсан байдаг.

Энэхүү тооллогоор хийгдэж байгаа гол ажлуудын нэг нь дурсгал бүрт хувийн дугаар өгөх явдал юм. 1987 оны бүртгэлд бүртгэгдсэн болон бүртгэлд тусгагдаагүй

шинээр тоолж байгаа дурсгал бүрд нэг бүрчлэн дугаар өгч байгаа ба дугаарын бүтэц нь “ГТХ2013.1-ээс эхлэн дэслэн дугаарлаж байгаа болно.

Бүртгэлийн дэвтэр дэх дэс дугаар болон шинээр өгч байгаа бүртгэлийн дугаарын дэс адил байх зарчмыг баримталсан. Ингэснээр тус хийдэд хадгалагдаж буй дурсгалын тоо ширхэгийн бодит дүнг гаргах, хуучин хувийн дугааруудын давхардлыг арилгах, дугааргүй дурсгалуудыг дугааржуулахад ач холбогдолтой болно. Бүртгэлийн үеэр дурсгал бүрийг хэмжиж, жинлэх ажлууд хийгдэж байгаа.

3-рт: Хувийн дугаарын асуудлыг шийдвэрлэн, бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн биет дээр шинээр өгсөн дугаар нэг бүрийг зохих журмын дагуу бичих, оёх, зүүх ажил:

Дурсгалын биет дээр Соёлын өвийн төвийн Сэргээн засварлах хэлтсээс өгсөн заавар зөвлөмжийн дагуу шинэ дугаарыг дурсгалын биет бичих, оёх, зүүх ажлыг хийж байна. Дурсгалын материалын төрөл зүйлээс хамааран хувийн дугаарыг бэхлэх арга зүй өөр өөр байна. Үүнд:

- ✓ Метал, шавар, модон зэрэг эдлэл дээр “Паралойд В72” уусмалыг дурсгалын биет дээр нимгэн түрхээд хэсэг хатаасны дараа зориулалтын усан суурьтай бэхэн үзгээр дугаараа бичээд дээрээс нь уг уусмалаа дахин түрхэн бэхжүүлэх.
- ✓ Даавуун хүрээтэй зээгт наамал, танка зургийн дугаарыг бичихдээ туузлан бэлтгэсэн цууямбуу цагаан даавуун дээр үзгэн балаар дугаараа бичээд оёх.
- ✓ Дугаар бичигдэх боломжгүй эрхи зэрэг зарим нэгэн эдлэл дээр ватум цаасан дээр дугаарыг бичээд, гадуур нь скочоор бүрж, нэг талаас нь мяндсан утсаар оосорлон уг дугаарыг өлгөж, зүүх.
- ✓ Захгүй танка зургийн хувьд зурагт гэмтэл учруулахгүй үүднээс танка зургийн ард НВ балын харандаагаар дугаарыг бичиж байгаа болно.

4-р: Бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн гэрэл зураг авах ажлын талаар:

Тоологдсон бурхан шүтээн, эд өлгийн зүйл бүрийн гэрэл зургийг нэгбүрчлэн 3-4 талаас мэргэжлийн түвшинд авч, баримтжуулан мэдээллийн сан бүрдүүлж байна.

Дурсгалын гэрэл зургийг авахдаа дэргэд нь хэмжилтийн шугам, өнгөний масштаб, цаасан дээр шинээр өгсөн дугаар нэгбүрчлэн бичиж тавьж байгаа болно.

Энэхүү тооллогоор тус хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийг гэрэл зургаар бүртгэн баримжуулах ажил анх удаа хийгдэж байгаагаараа онцлог бөгөөд тус хийд нь дурсгалуудын гэрэл зургийн иж бүрэн мэдээллийн сантай бүрдэх юм.

5-рт: Дурсгалуудын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах талаар авсан арга хэмжээний талаар:

Тооллогын явцад 2013 оны 12 дугаар сарын байдлаар нэн яаралтай засах шаардлагатай 19 ш бурхан шүтээнийг Соёлын өвийн төвийн сэргээн засварлах урланд авчирч сэргээн засварлах ажлыг хийлээ. Үрчийж хунирсанаас урагдахад хүрсэн 17 ш /16 Найдан/ бар зураг, 2 ш /Дүншигийн бурхан/ том хэмжээний зээгт наамлын /тус бүр нь 13000х165 см хэмжээтэй/ урагдлыг оёж, өлгөж зүүх өлгүүрийг дахин шинэчлэн засварлалаа.

Тус хийдэд хадгалагдаж байгаа бурхан шүтээний хадгалалтын нөхцөл байдлыг сайжруулж дараах арга хэмжээнүүд авсан болно. Үүнд:

- “Номын сангийн урд склад”-ад хадгалагдаж байгаа 780 зээгт наамал, танка зургийн гадуур боодлын цагаан даавуугаар боож баглах, цагаан даавуу нөмөргөн хадгалах зэргээр хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулсан.

- Гандан дуган дахь олон тоогоор нэг хайрцагт хадгалагдаж байгаа загал зургуудыг тоолохдоо зургийн завсар бүрт хүчил шүлтгүй зориулалтын цаас жийрэглэн хийж хадгалсан.

- Номын сан, Гандан дуганы гүнгэрваанд хадгалагдаж байгаа гэмтэж болзошгүй 53 ш захгүй танка зургуудийг шинээр жаазалж хадгалсан.

6-рт: Гар бичмэл бүртгэлийг цахим хэлбэрт оруулах талаар:

Соёлын өвийн төвөөс Гандантэгчэнлин хийдийн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх ажлын үндэс суурийг тавихад бүртгэн баримтжуулалтын арга зүйгээр туслан, Гандантэгчэнлин хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн бүртгэл буюу “Gandan Data” цахим бүртгэлийн програмыг боловсруулан зохиож, тус хийдэд суурилуулсан.

Одоо тус програмд тооллогоор шинээр үйлдэж байгаа гар бичмэл бүртгэлээ дижитал хэлбэрт шилжүүлэн оруулах ажлыг зэрэг хийж байна.

Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогын ажилд бурхан шүтээнийг цэвэрлэгээ арчилгаа, тоолсон бурхадыг гүнгэрваанд нь дэгийн дагуу буцаан залж байршуулах, урд өмнө нь бүртгэлд тусгагдаагүй дурсгалуудыг шинээр бүртгэх зэрэг ажилд нэлээдгүй цаг хугацаа, хүн хүч зарцуулан ажиллаж байна.

1.7. Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын дүн мэдээг авах, нэгтгэх , үзмэрийн үнэлгээний талаар

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын (хуучин нэрээр) 2012 оны 2 дугаар сарын 17-ны 74 тоот тушаалын дагуу зохих бэлтгэл ажлыг ханган 2012 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн музейн сан хөмрөгийн тооллогын ажлын хүрээнд тус төвийн Биет өвийг хамгаалах хэлтсээс музейн ажилтнуудад зориулсан тооллогын сургалтыг 2012 оны 8 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтын үеэр “Улс, аймгийн музейн улсын тооллого” гарын авлага 300 ширхэг хэвлүүлэн тарааж, тооллогын “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийг батлагдсан загварын дагуу **1000** ширхэг хэвлүүлэн музей тус бүрт 11 оронтой код өгч баталгаажуулан тооллогод хамрагдаж байгаа байгууллагуудад тараав. Энэ удаагийн тооллогоор өмнөх тооллогын бүртгэлд гарч байсан хувийн дугаар давхардах, дэс давхардах, алгасан зэрэг механик алдаануудыг илрүүлэн нэг мөр шийдвэрлэх, тооллогын нарийвчласан статистик гаргах зорилгоор “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийг үндэслэн **RIGISTER** програм хангамж зохиолгож тооллогод хамрагдсан газруудад суурилуулах ажлыг анх удаа хийлээ.

Улс, орон нутгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын дүнтэй танилцах тооллогын салбар комиссоос санал болгосон бүртгэлээс хасах, шилжүүлэх, маргаантай зэрэг асуудлуудыг батлагдсан маягтуудын дагуу үзэж танилцах хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож ССАЖ-ын Сайдын 2013 оны 09 сарын 04-ны өдрийн А/329 тоот тушаалаар орон нутагт ажиллаж баруун бүсийн 10 аймгийн 11 музей, говийн бүсийн 3 аймгийн музейд дүгнэлт гаргалаа. ССАЖСайдын А/392 дугаар тушаалаар нийслэлд үйл ажиллагаа явуулж Богд хааны ордон музей, Уран зургийн галерей, Археологийн хүрээлэн, Улаанбаатар хотын музей, Эрдэнэсийн сан зэрэг газруулал ажиллаж дүгнэлт гаргах ажил хийгдэж байна.

2012-2013 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын дүн мэдээг нэгтгэх ажил хийгдэж аймаг, орон нутгийн музейн дүнг 2013 оны 11 дүгээр сарын 5-нд, улсын чанартай музейн дүнг 12 дугаар сарын 16-ны өдөр ССАЖ-ын Сайдын шуурхай хуралдаанаар танилцуулга хийгдсэн. 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар улс, аймгийн нийт 41 музейд 80124 дэсийн 174227 ширхэг 403760 нэгж үзмэр, 19 аймгийн 259 сумын Орон нутаг сурталчлах танхим хамрагдаж нийт 20791 дэсийн 36478 ширхэг 42853 нэгж үзмэр тоологдсон байна. Тооллогын төв

комисс нь аймаг, орон нутгийн 8 музейгээс Ерөнхий бүртгэлээс хасаж, устгалд оруулахаар (ББЗМаягт 41)-д 273 дэсийн 361 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл, Ерөнхий бүртгэлээс хасаж, эргэлтийн хөрөнгөд шилжүүлэхээр (ББЗМ №43)-д 9 музейн 125 дэсийн 268 ширхэг үзмэр, Ерөнхий бүртгэлээс хасаж, үндсэн хөрөнгийн ангилал солих саналтай үзмэр, эд өлгийн зүйл (ББЗМ №44)-д 6 аймгийн музейгээс 299 дэсийн 408 ширхэг, улсын чанартай болон нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа Богд хааны ордон музей, Уран зургийн галерей, Улаанбаатарын хотын музейгээс нийт 160 дэсийн 780 ширхэг үзмэрийг Ерөнхий бүртгэлээс хасаж, эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх ББЗМ №43-д, Ерөнхий бүртгэлээс хасаж, үндсэн хөрөнгийн ангилал солих ББЗМ №44-д Богд хааны ордон музей, Эрдэнэ-зуу музейгээс 9 дэсийн 46 үзмэр, Ерөнхий бүртгэлээс хасаж, шилжүүлэх ББЗМаягт №45-т Чойжин ламын сүм музей, Монгол цэргийн музей, Эрдэнэ-зуу музейгээс нийт 15 дэсийн 43 ширхэг үзмэр оруулах нь зүйтэй гэж шийдвэрлээд байна.

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод хамрагдсан байгууллагын тоо:

| | | | |
|---|----------------------|----|---|
| 1 | Аймгийн музей | 23 | 21 аймгийн музей, Эрдэнэ-зуу музей, Дорнод аймгийн “Ялалт” музей |
| 2 | Хувийн музей | 1 | Данзанравжаагийн музей |
| 4 | Сүм хийд | 2 | Шанхын баруун хүрээ хийд, Төвхөн хийд |
| 5 | Улсын чанартай музей | 10 | Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Байгалийн түүхийн музей, Чойжин ламын сүм музей, Уран зургийн галерей, Монголын театрын музей, Төрийн түүхийн музей, Монгол цэргийн музей, Хөшөө цайдам музей |
| 6 | Байгууллагын музей | 5 | Үндэсний номын сангийн Үнэт ховор номын музей, Монгол банкны Эрдэнэсийн сангийн үзмэр, Улаанбаатар хотын музей, ШУА-н Палеонтологийн төв, ШУА-н Археологийн хүрээлэнгийн музей-лаборатори |
| | Нийт байгууллага | 41 | |

2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тооллогын нэгдсэн дүн мэдээг Монгол улсын Засгийн газрын хуралдаанд оруулах танилцуулга болон аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж тооллогод хамрагдсан байгууллагуудын тайлан мэдээг авч Соёлын өвийн УНБМСанд цаасан болон цахим хэлбэрээр хадгалах ажил хийгдэж байна.

Музейн үзмэрийн үнэлгээ

Музейн үзмэрт шинэчилсэн үнэ тогтоох ажлын бэлтгэл ажил Соёлын өвийн төв дээр 2012 оны 1 сараас хийж эхэлсэн болно. Музейн үзмэр, түүх, соёлын дурсгалыг үнэлэх ажил манайд анх 1972 онд БНМАУ-ын Соёлын яамны сайдын тушаалаар хийгдэж байсан байна. Энэхүү баримт болон шаардлагатай бусад судалгааг музей, мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран музейн үзмэр, түүх, соёлын дурсгалын үлгэрчилсэн үнэ тогтоох арга, үзмэрийн төрөл зүйлийн ангилал, жишиг үнийн жагсаалт бүхий журмын төслийг боловсруулан холбогдох дээд байгууллагад хүргүүлэв. Журмыг батлахаас өмнө туршилтын ажлыг Дүрслэх урлагийн музей, Төв аймгийн музей, Эрдэнэ-зуу музей, Хархорум музей, Хөшөө цайдам музей дээр хийж, бусад музейнүүд уруу цахим хэлбэрээр явуулж, саналыг авсны үр дүнд эцэслэн боловсруулах ажлыг Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Сангийн яам хамтран гүйцэтгэж, Сангийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 140 тоот тушаалаар “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”, түүний нэгдүгээр хавсралтаар “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-ыг батлав. Бүртгэлийн үнэ тогтоох ажлыг хялбар шуурхай болгох үүднээс тооллогын бүртгэлийн “REGISTER” програмд нэмэлт хийж бүртгэлийн үнийн хэсгийг дахин програмчлан шинэчлэх ажлыг Соёлын өвийн төв хийж тоологын үеэр шинэчилсэн үнийн дүн мэдээг авах бололцоогоор хангаж ажиллав.

2013 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар аймаг, орон нутгийн 25 музей дээр 23558538956 төгрөгний шинэчилсэн дансны үнэ, нийслэлийн 6 музей Байгалийн түүхийн музей, Чойжин ламын сүм музей, Монголын театрын музей, Үндэсний номын сангийн Үнэт ховор номын музей, Улаанбаатар хотын музей, Монгол цэргийн музей дээр нийт 9722244737 төгрөгний шинэчилсэн дансны үнэлгээ хийгдээд байна.

1.8. “Архангай аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цуврал Х дэвтэр” хэвлэх

2008-2013 оны хооронд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл судалгаанд хамрагдаж, аймаг тус бүрийн үл хөдлөх дурсгалыг сурталчилсан цуврал дэвтрийн 10 дахь дугаарыг өмнөх онд бүртгэж, тоолсон Архангай аймгийн үл хөдлөх дурсгалуудаар гаргахаар эхийг бэлтгэн хэвлэлтэд шилжүүлээд байна.

2012 оны 12 дугаар сарын сүүлчээр уг цуврал 1000 ширхэг хэвлэгдэх ба манай улсын музей, номын сан, их дээд сургууль, сумдын соёлын төвүүдэд үнэ төлбөргүй тараагдах юм.

1.9 “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр-II”-ийг боловсруулах

Үндэсний соёлын өвийн талаарх бүрэн мэдээллийг бүрдүүлэх, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулж, соёлын өвийн мэдээллийг тоон технологи, электрон хэлбэрт оруулан нэгдсэн сүлжээ бий болгон, мэдээллийг шуурхай харилцан солилцох, найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолоор баталж, 2006-2008 онуудад хэрэгжүүлсэн юм.

2009 онд “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (хуучин нэрээр) хяналт-шинжилгээ хийж дүнг Засгийн газраар хэлэлцүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн зорилтууд үндсэндээ биелэгдсэн, цаашид хөтөлбөрийг улам бүр өргөн хүрээг хамруулан өргөжүүлэх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн юм.

2006-2008 онд хэрэгжүүлсэн “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-нь хэрэгжилт үндсэндээ улс, аймгийн музейг хамарсан бөгөөд улсын хэмжээнд сум орон нутаг судлах танхим болон түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх ажил өргөнөөр хамарч чадаагүй юм.

Иймд 2014 онд “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр-II”-ийн төслийг боловсруулан ССАЖЯаманд 2014 оны 10 дугаар сард өргөн барьлаа. Энэхүү шинээр боловсруулсан хөтөлбөрт улс, аймгийн музейн үзмэрийг бүртгэх төдийгүй улсын хэмжээний нийт 330 сум, 9 дүүргийг өргөн

хамруулан соёлын биет болон биет бус соёлын өвийг бүртгэн баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэхээр тусгагдсан юм.

ХОЁР. Байгууллага (Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтэс)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

2.1 Монгол туульчдын намтар, уран бүтээлийн УНБМС бүрдүүлэх

Соёлын биет бус өвийн сан хөмрөгт баруун монгол, төв халхын нэрт туульчдын төлөөлөл болсон 18 хүний намтар, уран бүтээлийн сан бүрдүүлэв.

2.1.2 “Монгол туульчдын намтар” ном хэвлүүлэх

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиолын сектортой хамтран XIX, XX зууны Ойрад, Халх, Халимаг, Өвөрлөгч, Буриад зэрэг туургатны 60 туульчийн намтар, уран бүтээлийн тухай мэдээллийг агуулсан “Монгол туургатны туульчид” ном бүтээж, судлаачид, өвлөгчид, төв хөдөөгийн номын сангуудад түгээв.

2.2 Хотгойд ардын дууны БМС бүрдүүлэх

Хөвсгөл аймгийн Арбулаг, Бүрэнтогтох, Мөрөн сум дахь ар Хотгойдууд, Завхан аймгийн Нөмрөг, Түдэвтэй, Тэлмэн сумдын Өвөр Хотгойдуудын дунд хийсэн судалгааны ажилд түшиглэн хотгойд ардын дууны БМС бүрдүүлэх ажлыг хийлээ. Мөн хотгойд дууны уламжлалыг хадгалж хамгаалах зорилгоор СӨТ-өөс МУГЖ Д.Надмидын “Хотгойдын уянга” аудио CD-г сургалт сурталчилгаанд зориулан хэвлэв.

2.3 СББӨ-ийг өвлөн уламжлагчдын судалгаа, бүртгэлийн ажлыг орон нутагт зохион байгуулах

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 2013 оны 5 дугаар сарын 6-8-ны хооронд зохиогдсон “Бид бүжиглэх дуртай-1000” мянган бий бийлээчдийн тоглолт, 2013 оны 7 дугаар сард Завхан аймагт зохион байгуулагдсан “Завхан аймаг-90”, “1000 морин хуурч, 2222 уртын дуучдын тоглолт”-ыг дүрс бичлэг болон фото зургаар баримтжуулан ажиллав.

Өмнөговь, Баянхонгор аймгуудад 2013 оны 3 дугаар сарын 25-наас 4 дүгээр 01-ны хооронд томилолтоор явж “Малд төл авахуулах зан үйл”-ийг төрөл зүйлд хамаарах бүртгэл судалгаа бүхий бүртгэн баримтжуулах ажлыг хийв.

2.4 “СББӨ-ийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхэд өвлөгчдийн оролцоог дээшлүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулах

Японы итгэлцлийн сангийн дэмжлэгээр Соёл, спорт, аялал жуулчлалын яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, тус төвийн СББӨХХ-ийн хамтран хэрэгжүүлж байгаа соёлын биет бус өвийг хамгаазах цуврал сургалтын 3 дугаар болох “Хамт олонд түшиглэсэн соёлын биет бус өвийн бүртгэл” үндэсний сургалтыг 2013 оны 5 дугаар 22-28-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Төв аймагт зохион байгууллаа. Сургалтанд 21 аймгийн Соёл спорт, аялал жуулчлалын газрын соёл хариуцсан мэргэжилтнүүд, шагайн харвааны өвлөн уламжлагчид, ССАЖЯ, Соёлын өвийн төвийн холбогдох ажилтнууд нийт 48 хүн хамрагдлаа. Сургалтыг ЮНЕСКО-гийн СББӨ-ийн салбарын зөвлөх, Токио дахь Бодлого судлалын Үндэсний хүрээлэнгийн профессор Норико Айкава, Сингапур улс дахь Милоу студийн Өвийн төсөл ба харилцаа холбооны хэлтсийн дарга Сюзанн Ог нар удирдан явуулсан бөгөөд сургалтын дадлага хичээлийг Төв аймгийн Зуунмод хотноо шагайн тойром дээр явуулав.

2.5 “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”-д бүртгэгдсэн цуур хөгжмийн уламжлалт өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулах, “Цуурын өв уламжлал хамгаалах арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”-д орсон “Тууль”-ийг хамгаалах үйл ажиллагаа явуулах

2.5.1 “Монгол цуур” үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн зөвлөмж, оролцоотойгоор уг хөтөлбөрийн төслийг боловсруулж ССАЖЯ-нд хүргүүлэв. Үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд “Цуурын уламжлалт урлагийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлыг Соёлын Өвийн Төв, “Хүннү цуурчдын холбоо” ТББ хамтран 2013 оны 8 дугаар сарын 14-нд зохион байгууллаа. Хуралд 30 гаруй цуурч өвлөгч, эрдэмтэн судлаачид оролцож, монгол цуур хөгжмийн түүх, уламжлал, урын сан, бусад урлагтай харилцан шүтэлцэх нь, цуурын урын сан, цуур хөгжмийн урлал, ур хийц бүтэц, өнөөгийн байдал, цуурын шавь сургалтын уламжлалыг танхимын сургалттай хослуулах арга замын тухай зэрэг 10 гаруй илтгэл хэлэлцэв. Хурлын илтгэлүүдийг эмхтгэн “Цуурын уламжлалт урлагийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл” номыг хэвлэн гаргав.

Эрдэм шинжилгээний хурлын үеэр “Монгол цуур” үндэсний хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлж, өвлөгчид, судлаачдын санал бодлыг тусгав.

2.5.2 ССАЖЯ, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, ЮНЕСКО-гийн МҮК-тэй хамтран “Төв Азийн тууль симпозиум, их наадам II”-ыг 2013 оны 8 дугаар сарын 5-7-нд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Монгол, ОХУ-ын Буриад, Тува, Халимаг, Саха (Якут), БНХАУ-ын Шинжаан уйгарын өөртөө засах орон болон Өвөр Монголын өөртөө засах орон, АНУ, БНСУ, Казакстан, Тажикстан, Конго зэрэг 15 орны 100 гаруй эрдэмтэн судлаачид туульчид оролцлоо. Симпозиум, их наадмын хүрээнд эрдэм шинжилгээний хурал, туульч эрдэмтдийн уулзалт ярилцлага, Монгол улсаас ЮНЕСКО-гийн СББӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн өвүүдийн цоморлиг тоглолт, Тууль хайлах цаг, туульчдад малгайн тэмдэг титэмлэх ёслол зэрэг арга хэмжээг зохион байгуулав. Туульчдад “Туульч” хэмээх цол, малгайн тэмдэг олгосон нь тэдний нэр хүндийг өргөж, идэвх урмыг сэргээсэн шинэлэг зүйл болов.

2.5.3. ЮНЕСКО-гийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлэх “Монгол туулийн өвийг хамгаалах, сэргээн амилуулах” төслийг эхлүүлж, туулийн сургагч багш нарын сургалт семинарыг 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, сургалтыг хэрэгжүүлэх арга зам, сургалтын арга зүй, хугацаа, хүрэх үр дүнгийн талаар харилцан ярилцаж, тууль судлаач, эрдэмтэд, шилдэг өвлөгчид, багш сурган хүмүүжүүлэгчдээр хичээл заалгав.

2.6 СББӨ-ийн програм хангамжийн I хувилбар

Тус өтвийн ББӨХХ-ээс 2011 оноос хойш Соёлын биет бус өвийн олон төрөл зүйл, СББӨ-ийг өвлөн уламжлагчдын талаарх мэдээллийн сан, статистик мэдээлэл боловсруулах, хайлт хийх програм хангамжтай болох талаар нилээдгүй цаг хугацаа зарцуулж ажилласаны үр дүнд програм хангамжийн эхний хувилбар боловсруулагдаж, уг программыг туршилтын журмаар ажиллуулж байгаа ба одоогийн байдлаар уг програмд 270 өвлөн уламжлагчийн бүртгэл мэдээллийг оруулаад байна. Цаашид боловсронгуй болгох үйл ажиллагаа үргэлжлэх болно.

ГУРАВ. Байгууллага (Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

3.1 Улс, аймгийн 16 музейн 183 ширхэг үзмэрийг бэхжүүлэх сэргээн засварлах:

2013 онд Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс нь улс, аймгийн 16 музейн 183 ширхэг үзмэрийг бэхжүүлж сэргээн засварлахаар төлөвлөсөн байна. Үүнээс 16 музейн 155 үзмэрийг сэргээн засварлаж, энэ онд сэргээн засварлах ажил хийгдээгүй 47 ширхэг үзмэрийг 2014 онд сэргээн засварлахаар төлөвлөгөөнд оруулав. Мөн энэ онд төлөвлөсөн ажлаас гадна нэмэлт захиалгаар 136 ширхэг үзмэрт цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

| № | Байгууллага | Нийт сэргээн засварлах | Хүлээж авсан үзмэрийн | Сэргээн засварлагд-аж байгаа | Сэргээн засварлагд-сан | Засварт ороогүй үзмэр |
|-----|---------------------------|------------------------|-----------------------|------------------------------|------------------------|-----------------------|
| 1. | Богд хааны ордон музей | 3ш | 3ш | | 3ш | |
| 2. | Уран зургийн галерей | 15ш | 15ш | | 15ш | Засвар |
| | | | 25ш | | 25ш | Цэвэрлэгээ |
| 3. | Монголын үндэсний музей | 1ш | | | | Ирээгүй |
| 4. | Говь-сүмбэр аймгийн музей | 4ш | 4ш | | 4ш | |
| 5. | Увс аймгийн музей | 2ш | 2ш | | 1ш | 1ш |
| 6. | Төв аймгийн музей | 6ш | 6ш | | 6ш | |
| 7. | Дундговь аймгийн музей | 8ш | 8ш | | 4ш | 4ш |
| 8. | Чойжин ламын сүм музей | 1ш | 1ш | | 1ш | |
| 9. | Хөвсгөл аймгийн музей | 7ш | 7ш | | 5ш | 2ш |
| | | | | | | |
| 10. | Гандан хийд | 10ш | 10ш | | 10ш | |

| | | | | | | |
|-----|--|-------------|-------------|--|-------------|------------|
| 11. | Баянхонгор аймгийн музей | 6ш | 6ш | | 3ш | 3ш |
| 12 | Говь-алтай аймгийн музей | 2ш | 2ш | | 2ш | |
| 13 | Хан богд сумын соёлын төв | 50ш | 50ш | | 50ш | |
| 14 | Эрдэнэ зуу музей | 17ш | 17ш | | 5ш | 12ш |
| 15 | ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургууль | 1ш | 1ш | | 1ш | |
| 16 | УБИС – Гол мод -2 хүннүгийн олдворууд | 50ш | 45ш | | 20ш | 25ш |
| | Нийт | 183ш | 202ш | | 155ш | 47ш |

3.1.1 2013 онд нэмэлт захиалгаар цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварласан музейн

үзмэрүүд:

| № | Байгууллага | Метал | Шавар | Мод | Даавуу | Цаас | Тайлбар |
|----|-------------------------------------|-------|-------|-----|--------|------|--|
| 1. | Хархорум музей | | | 30ш | | | Баяннуур – археологийн олдвор |
| 2. | МҮТ- Музей археологийн олдвор | 18ш | 3ш | 3ш | 4ш | | Археологийн олдвор |
| 3 | Гандан хийд | | | | 2ш | 9ш | 19-н бар зураг , 2 зээгт наамал бурхад |
| 4 | Дүрслэх | | | | 6ш | | Танка зураг |

| | | | | | | | |
|----|---|------------|-----------|------------|------------|------------|-------------------------------------|
| | урлагийн музей | | | | | | |
| 5 | Монгол цэргийн музей | 1ш | | | | | Монгол цэргийн сэлэм |
| 6. | Өмнө-говь аймгийн музей | | | | 1ш | | Хөөрөгний даалин |
| 7 | ШУТИС-ийн нийгмийн технологийн сургууль | 1 ком | | | | | Суран бүс хүрэл чимэглэлүүдийн хамт |
| 8. | Чулуун судар төсөл | | | | | 31ш | Хадны бичээсний дардас |
| 9. | Хан богд сумын соёлын төв | 25ш | | | | | Төмөр хүрэл сумны зэв |
| | Нийт | 45ш | 3ш | 33ш | 15ш | 40ш | 136 ш |

3.1.2 2013 онд нэмэлт захиалгаар түүх, соёлын дурсгал, соёлын өвийн материалын бүтэц найрлага тогтоох оношилгоо судалгааны ажил

| № | Музейн нэрс | Үзмэрийн нэрс | Хийгдсэн ажил |
|----|------------------------|---|--|
| 1. | Дүрслэх урлагийн музей | 1.Занабазарын өөрийн хөрөг . / танка зураг / 2. Занабазарын эхийн хөрөг / танка зураг / 3.Доржсэмбэ /танка зураг / 4. Гонгор / танка зураг / | Зургийн өнгө будаг, грунтын найрлага, бүтэцийг тодорхойлох, зургийг бүтээсэн арга техникийг судлах |
| 2. | Богд хааны ордон музей | 1.Богдын малгайн алтан очир, очирын шургааг 2. Богдын модиг / алтан чимэглэл / 3. Богдын додиг / алтан чимэглэл / | Металын найрлага бүтэцийг тодорхойлох |

| | | | |
|----|-------------------------|----------------|---------------------------------------|
| | | | |
| 3. | Дунд-говь аймгийн музей | 1. Хүрэл эдлэл | Металын найрлага бүтэцийг тодорхойлох |

3.1.3 2013 онд нэмэлт захиалгаар хийгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах ажил

1. Завхан аймгийн Дөрвөлжин сумын төвөөс баруун хойш 22 км орчимд орших Баян-айраг уулын өвөрт байрлах Баян айраг уул уурхайн баазаас баруун хойш 1.2 км, жалгын эхний хадархаг жижигхэн толгойн урд шувтарга үзүүрийн 6 - н хэсэг хадан дээр, янгир нум харваж буй хүн зэргийг дүрсэлсэн олон тооны зураг бүхий хадны дурсгал уул уурхайн ашиглалтын талбайд орсон тул нүүлгэн шилжүүлэх ажлыг зохих зөвшөөрөлүүдийг үндэслэн, шилжүүлж байрлуулах ажилд арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа.

Завхан аймгийн Тэлмэн сум Дунд Шургахын аманд орших Түрэгийн үед холбогдох цайвар саарал боржин чулуун толгойгүй хүн чулуу дурсгалыг нутгийн ард иргэд тахин шүтдэг тул орон нутгийн иргэд удирдлагын зүгээс дээрх хүн чулууг толгойтой болгож сэргээн засварлуулах хүсэлтийг ССАЖЯаманд тавьжээ. Хүсэлтийн дагуу яамнаас манай төвд хандсаны дагуу эх дурсгал дээр толгой гүйцээж сэргээн засварлах боломжгүй гэж үзэн, эх хэв авч адил хэмжээгээр ижил төрлийн чулуугаар хүн чулууг анхны байдалд ойртуулан шинээр хийсэн болно. Хуулбарлаж хийсэн хүн чулуун толгойг тухайн дурсгалтай нэгэн үеийн түрэг хүн чулуудын толгойн хэлбэр загварт судалгаа хийж зохих судлаачидын зөвлөмжийн дагуу загварыг гаргаж хийсэн. Эх дурсгалын гадна талын бохирдолыг цэвэрлэж өнөөгийн байгаа байдлаар нь хадгалах нь зүйтэй гэж үзсэн.

3.2 Их бурхант дурсгалыг сэргээн засварлах

2013 онд Их бурхант дурсгалыг сэргээн засварлах ажлын эхний үе шатыг 2013 оны 05-р сарын 20-ны өдрөөс 07-р сарын 05-ний өдрийн хооронд орон нутагт ажиллаж Гол шүтээн Жанрайсэг бурханы лагшин, 6 ширхэг Аюуш бурхадын сэргээн засварлах ажлыг 50-60% -ийг хийж гүйцэтгэсэн.

Хоёр дахь шатны ажлыг 2013 оны 08-р сарын 20-ны өдрөөс 2013 оны 10-р сарын 10-ны хооронд хэрэгжүүлж Гол шүтээн Жанрайсэг бурханы лагшиныг

засварлах ажлын 80% -ийг, 6 ширхэг Аюуш бурхадын сэргээн засварлах ажлын 95 %-ийг, гадна талын чулуун хэрмэн хашааг засварлах ажлыг 100 % хийж гүйцэтгэсэн. Мөн энэ хугацаанд археологийн хүрээлэнгийн мэргэжилтэнгүүдтэй хамтарч археологийн малталт судалгааны ажил хийгдсэн.

Хэрмэн хашааны хаалга, дөрвөн булангийн суврагыг шинээр хийх ажлын хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай хамтарч ажиллан 2014 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

3.3 Баяннуурын цогцолбор дурсгалын ханын зургийг авран хамгаалах

Булган аймгийн Баяннуур сумын нутаг Улаан хэрмийн шороон бумбагар хэмээх газарт орших VI-VII зууны үед холбогдох Түрэгийн үеийн бунхант оршуулгын байгууламжын ханын зургийг хуулж авах ажлын санхүүжилт бүрэн шийдвэрлэгдээгүй шалтгаанаас энэ ажил төлөвлөсөн хугацаандаа эхлээгүй байна. Гэвч тус төвийн Сэргээн засварлах хэлтсээс дээрх дурсгалт газар 2013 онд 4-5 удаагийн судалгааны ажил, сургалт, хамгаалалтын ажлыг ЮНЕСКО болон японы судлаачид, өөрсдийн хүчээр хийжээ.

-“Улаан хэрмийн шороон бумбагар” дурсгалын бунхны ханан дахь ханын зургийн хадгалалтын өнөөгийн байдалтай танилцах, цаашдын хамгаалалт сэргээн засварлалтын талаар зөвлөлдөх ажлаар Япон улсын Киото хотын Сага их сургуулийн профессор Масаки Нака, Киото хотын түүх соёлын дурсгалын сэргээн засварлалтын Сайшики Секкей компанийн захирал сэргээн засварлагч Ономүра, Китамүра Рио, тус төвийн сэргээн засварлагч С.Чинзориг, Д.Нямдорж нар 2013 оны 6 дугаар сарын 03-нд тус дурсгал дээр ажилласан.

-Мөн 2013 оны 8 дугаар сарын 6-13-ны өдрүүдэд Соёлын өвийн төвийн мэргэжилтэнгүүд Киото хотын түүх соёлын дурсгалын сэргээн засварлалтын Сайшики Секкей компанийн мэргэжилтэнгүүдтэй хамтарч ханын зургийн зарим хэсэгт хуулбарыг хийх туршилтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

-2013 оны 9 дүгээр сарын 03-наас 09-ний хооронд Улаан хэрмийн Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг мэргэжлийн өндөр түвшинд авсан гэрэл зургаар баримтжуулах ажилд бэлтгэж ханын зургийн гадарт тархсан хөгц мөөгөнцөрийн бохирдолыг цэвэрлэх ажлаар Соёлын өвийн төвийн сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, сэргээн засварлагч Д. Нямдорж, Г.

Ууганчимэг, О. Оюунчимэг, Б.Мягмарсүрэн, сан хөмрөгийн эрхлэгч М. Дэжид, жолооч Б. Эрдэнэчимэг нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллав.

-2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн ЮНЕСКО-ийн Бээжин дэхь салбартай хамтран байгуулсан 4500217569 тоот гэрээний дагуу ЮНЕСКО-гийн мэргэжилтэн Итали улсын иргэн Клаудио Марготинни, Соёлын өвийн төвийн сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, сэргээн засварлагч Д. Нямдорж, гадаад харилцааны мэргэжилтэн Ц. Цолмон, сан хөмрөгийн эрхлэгч М. Дэжид, жолооч Б. Эрдэнэчимэг нарын бүрэлдэхүүнтэй баг Улаан хэрмийн Шороон бумбагарын бунхант булшны хөрсний бүтэц, чулуулгийг судлах, судалгааны ажлын дүгнэлтийг үндэслэн цаашид авах арга хэмжээг тодорхойлох ажлаар 2013 оны 10 дугаар сарын 2-8-нд Улаан хэрмийн Шороон бумбагарын бунханд ажилласан.

-2013 оны 11 дүгээр сарын 13-18-нд Улаан хэрмийн Шороон бумбагарын бунхант булшны өвөлжилтийн бэлтгэд ажлыг хангах, үүдэвчний ханын зураг, бэхэлгээний модонд хөгц мөөгөнцөрийн бохирдолыг цэвэрлэж бэхжүүлэх, бунханы дулаалгын хучилтыг хийх ажлаар Соёлын өвийн төвийн сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, сэргээн засварлагч Д. Нямдорж, А. Мөнгөнцоож, Э. Батжаргал, Н. Бат-эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй баг бунханд ажиллалаа

3.4 Рашаан хадны хавтан самбар чулууг босгож байрлуулах

Хэнтий аймгийн Батширээт сумын хутагт орших Рашаан хадны дэргэдэх тамга тэмдэгт хавтан чулууг анхны төрх байдалд ойртуулан босгох, хавтангийн орчмын ухсан нүхийг булж анхны эх төрх байдалд оруулах ажлыг 2013 оны 2 дугаар улиралд хийхээр төлөвлөсөн хэдий ч хүн хүчний хосдол, ажлын хэт их ачааллын улмаас хийгдээгүй болно. Мөн ССАЖЯам, Хэнтий аймгийн ССАЖГазраас Рашаан хадны дурсгалт газрын орчимд “Монгол төрийн тамганы орд өргөө” байгууламжийг барих ажлын судалгаа хийгдэж буй тул тамгат хавтанг газраас нь хөдөлгөхийг урьтал болгоогүй болно

ДӨРӨВ. Бусад ажил, үйлчилгээ

4.1 “Азийн орнуудын музейн хөгжил, музей судлал, шинэ хандлага” музейн ажилтнуудад зориулсан ном хэвлүүлэх

Өмнөх 2012 оны 7 дугаар сард зохиогдсон Япон улсын Соёлын сантай хамтран “Азийн орнуудын музейн хөгжил, музей судлал, шинэ хандлага” сургалт семинарыг Өвөрхангай аймгийн Хархорин болон Улаанбаатар хотод зохион байгуулсан билээ.

Тус сургалтаар соёлын өв музейн үзмэрийг хадгалж хамгаалах арга зүй, хадгалалт хамгаалалтын тогтолцоо, музейн боловсрол зэрэг үндсэн чиглэлээс гадна байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны дараа соёлын өвийг хэрхэн хамгаалж буй талаарх туршлагын талаар танилцуулсан нь музейн ажилтнуудын ажил, мэргэжилд ихээхэн тустай юм.

Уг сургалтын материалуудыг нэгтгэн 2013 оны 04 дүгээр сард музейн ажилтнуудад зориулан “Азийн орнуудын музейн хөгжил, музей судлал, шинэ хандлага” гарын авлага номыг 200 хувь хэвлүүлэн, музейнүүдэд тараав.

4.2 2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын ерөнхий бүртгэлийн програм хангамжийг сайжруулах

Энэ ажлын хүрээнд програмыг хөгжүүлэгч “Сайбер-Андромеда” ХХК-тай хамтарч хоёр удаагийн сайжруулалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

1. Музейгээс ирсэн санал хүсэлтийг үндэслэн хийсэн сайжруулалтын ажил /2013 оны 03-04 дүгээр сар/
 - Програмыг сүлжээгээр ажиллах боломжтой болгох,
 - Дэс дугаар, тоо ширхэг, иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн нийт тоо ширхэгийн тоон дүнг Дурсгалууд цэсэнд гардаг болгох,
 - Хайлт, шүүлтийн үр дүнг жагсаалтаар хардаг, хэвлэдэг болгох.
2. Дансны шинэчилсэн үнэ тогтоохтой холбоотой сайжруулалтын ажил /2013 оны 06-р сар/
 - Програмд шивэгдсэн үзмэр тус бүр дээр бүртгэлийн шинэчилсэн үнэ оруулах талбар бий болгох,
 - Тухайн үзмэрийн бүртгэлийн үнийг тогтоохдоо Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг үнэлэх журмын аль аль заалтыг хэрхэн ашигласан тухай түүх (history) үүсгэж хадгалах, хэвлэх боломж бий болгох,
 - Уг програмаас тухайн музейн нийт үзмэрийн үнийн дүнг тооцоолон гаргах, хэвлэж боломж бий болгох.

4.2 Register програмын хэвийн ажиллагааг хангах, тооллогын дүн мэдээг нэгтгэх ажил

Музейн үзмэрийн ерөнхий бүртгэлийн Register програмын хэвийн ажиллагааг хангах ажлыг өдөр тутам хийж гүйцэтгэсэн болно. Register програмтай холбоотой асуудлаар нийт 34 байгуулагатай 100 гаруй удаа холбогдсон байна. Музейнүүдийн нийтлэг алдаануудыг дурдвал:

1. Компьютер нь вирустэж ямар ч программ ажиллахааргүй болж ахин форматалж шинээр суулгахаас аргагүй болж байсан.
2. MS Windows үйлдлийн систем алдаа гарч, genuine зааж алдаа гарч байсан ба үүнээс бол программд шинэчлэл хийгдэхгүй байсан.
3. Программд шинээр update хийж мөн шинэчлэл хийхэд гарч байсан нийтлэг алдаа нь үйлдлийн систем нь update татаагүй зарим жижиг тохиргоонууд нь байхгүй хийгдээгүй жишээ нь: цагийн бүс таараагүй программд шинэчлэл хийгдэхгүй алдаа гарч байсан.
4. Программд шаардлагатай SQL 2005, SQL 2008 тус 2 программ алдаа гарч байсан зарим музейнууд нь андуурч устгаж юм уу SQL 2008 программын SQL Server Configuration Manager-SQL Server(SQLEXPRESS), SQL Server(MSSQLSERVER) тус 2 нь stop болж Register программ нь орохгүй алдаа гарч байсан.
5. Шинэчилсэн үнийн update Register программд оруулж эхэлэхэд гарч байсан нийтлэг алдаа нь ихэнхдээ цагийн бүс таарахгүй мөн зарим жижиг update татагдаагүй байсан учраас алдаа гарч байсан. Шинэчилсэн үнийг оруулах тухайд нийтлэг гарч байсан алдаанууд нь хуучин үнийн сонголтоо буруу сонгож байсан ба жишээ нь: хуучин үнийг баримлах шаардлагагүй үзмэр дээр хуучин үнийг баримталж буруу үнэ гарч байна гэж андуурч байсан үнийг тэр доор нь тайлбарлаж өгсөн.
6. Register программ дээр зарим жижиг алдаанууд гарч байсан ба гарсан тухай бүрт нь ямар алдаа гарсан үгүйг шалгаж үзэж тэр дор нь баазыг хуулж аван алдаа засч байсан.

4.3 Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн бүртгэл

2013 онд музейн сан хөмрөгийн улсын тооллого явагдаж, музейн ажилтнууд тооллогын ажилдаа түлхүү оролцон ажиллаж байгаагаас шалтгаалан музейгээс “RCH” бүртгэлийн програмдаа үзмэрээ бүртгэн оруулах ажил өмнөх жилүүдийг

бодвол харьцангуй удаашралтай байна. 2013 оны байдлаар **1305** дэсийн **1501** ширхэг үзмэр бүртгэгдсэн байна.

| № | Байгууллагын нэрс | УНБМСанд нийт бүртгэгдсэн | | 2013 онд бүртгэгдсэн | |
|----|---|------------------------------|---------------|-------------------------|----------------|
| | | Дэс | Тоо ширхэг | Дэс | Тоош ширхэг |
| 1 | Богд хааны ордон музей | 4089 | 4090 | 0 | 0 |
| 2 | Чойжин ламын сүм музей | 1115 | 6149 | 0 | 0 |
| 3 | Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей | 2246 | 2357 | 3 | 3 |
| 4 | Монголын үндэсний музей | 3308 | 5561 | 761 | 854 |
| 5 | Байгалийн Түүхийн музей | 1267 | 1267 | 0 | 0 |
| 6 | Эрдэнэ Зуу музей | 1200 | 2359 | 0 | 0 |
| 7 | Уран Зургийн галерей | 1619 | 1642 | 0 | 0 |
| 8 | Монголын Театрын музей | 3504 | 4037 | 0 | 0 |
| 9 | Монгол улсын үндэсний номын сан | 630 | 1122 | 0 | 0 |
| 10 | БХЯ-ний харьяа Монголын цэргийн музей | 314 | 314 | 0 | 0 |
| 11 | ШУА-ийн харьяа Палеонтологийн төв | 67 | 69 | 0 | 0 |
| 12 | ШУА-ийн Археологийн хүрээлэн | 327 | 2927 | 50 | 54 |
| 13 | Улаанбаатар хотын түүх шинэчлэн байгуулалтын музей | 407 | 611 | 0 | 0 |
| 14 | Монголын бурхан шашинтны төв Гандантэгчинлэн хийд | | | 0 | 0 |
| 15 | Архангай аймгийн музей | 952 | 1746 | 117 | 217 |
| 16 | Баян-Өлгий аймгийн музей | 878 | 1771 | -3 | -3 |
| 17 | Баянхонгор аймгийн музей | 1589 | 3796 | 157 | 342 |
| 18 | Булган аймгийн музей | 1512 | 2273 | 0 | 0 |
| 19 | Говь-Алтай аймгийн музей | 1396 | 1531 | 414 | 414 |
| 20 | Говьсүмбэр аймгийн музей | 424 | 424 | 0 | 0 |

| | | | | | |
|----|--------------------------|--------------|--------------|-------------|-------------|
| 21 | Дархан-Уул аймгийн музей | 866 | 866 | 0 | 0 |
| 22 | Дорноговь аймгийн музей | 626 | 1120 | 0 | 0 |
| 23 | Дорнод аймгийн музей | 1403 | 3225 | 0 | 0 |
| 24 | Дундговь аймгийн музей | 647 | 657 | -389 | -671 |
| 25 | Завхан аймгийн музей | 1260 | 1260 | -423 | -584 |
| 26 | Орхон аймгийн музей | 610 | 611 | 1 | 1 |
| 27 | Өвөрхангай аймгийн музей | 516 | 990 | -7 | -12 |
| 28 | Өмнөговь аймгийн музей | 913 | 965 | 0 | 0 |
| 29 | Сүхбаатар аймгийн музей | 343 | 343 | 0 | 0 |
| 30 | Сэлэнгэ аймгийн музей | 1007 | 1025 | 0 | 0 |
| 31 | Төв аймгийн музей | 1487 | 1824 | 0 | 0 |
| 32 | Увс аймгийн музей | 945 | 2644 | 337 | 560 |
| 33 | Ховд аймгийн музей | 192 | 192 | -21 | -21 |
| 34 | Хөвсгөл аймгийн музей | 1799 | 3861 | 0 | 0 |
| 35 | Хэнтий аймгийн музей | 1269 | 1692 | 6 | 6 |
| 36 | Төрийн Түүхийн музей | 645 | 654 | 0 | 0 |
| 38 | Хөшөө цайдам музей | 126 | 173 | 0 | 0 |
| 39 | Хархорум музей | 445 | 557 | 302 | 341 |
| 40 | Данзанравжаамузей | 7 | 7 | 0 | 0 |
| | Нийт | 41950 | 66712 | 1305 | 1501 |

4.4 Архивын програм хийх ажил

Соёлын өвийн төвийн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн архивт хадгалагдаж байгаа цаасан болон цахим суурьтай баримт материалын бүртгэлийн програм зохиох ажлыг “Урансофт” ХХК-тай хамтран 2012 оны 12-р сарын 20-ны өдөр эхлүүлж 2013 оны 4-р сарын 22-ны өдөр програмын хүлээн авсан.

Програмд мэдээлэл оруулахад шаардлагатай мэдээллийн ангиллыг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Архивын програмтай болсноор цаасан суурьтай бүх баримтууд дижитал хэлбэрт шилжиж, түргэн шуурхай цаг алдахгүй мэдээллээр хангагдах бололцоотой болно.

4.5 Музейнүүдэд тоног төхөөрөмж нийлүүлсэн талаар

Улс, аймгийн музейн бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалтын ажилд шаардлагатай 12 нэр төрлийн тоног төхөөрөмжийг “Хазаарбат” ХХК-наас хүлээн авч Соёл, Спорт, Аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын баталсан нэр бүхий 38 музейд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа. Эдгээр тоног төхөөрөмжүүдийн нэр төрөл, овор хэмжээ их байсан тул тэдгээрийг хадгалах, хүлээлгэн өгөхөд нилээдгүй хүндрэл учирч байв. Одоо ч овор хэмжээ ихтэй хүндрүүлэгчтэй сейф зэргийг бүрэн хүлээлгэн өгч дуусаагүй байна.

Энэ ажлын хүрээнд зарим музейд тоног төхөөрөмжтэй ажиллах анхан шатны заавар зөвлөгөө өглөө.

Тоног төхөөрөмжийг шалган музейнүүдэд хүлээлгэн өгөх явцад үйлдвэрийн гэмтэлтэй GPS -5 ширхэг, Чийг дулаан хэмжигч -5 ширхэг тус тус илэрсэнийг нийлүүлэгч талд буцаан, шинээр солиулах ажлыг хийлээ.

4.6 Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн дэргэд шинээр байгуулах музейн үндсэн чиглэлийг боловсруулах ажил

Соёл, спорт, аялал жуулчлалын Сайдын 2013 оны А/61 тушаалын дагуу тус хийдийн дэргэд шинээр байгуулах музейн төслийг боловсруулах ажлын хэсэгт тус төвийн Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа 2013 оны 01 дүгээр сараас эхлэн ажиллав. Тус хийдтэй хамтран Гандантэгчэнлин хийдийн шинээр байгуулах музейн үндсэн чиглэлийг боловсруулан гүйцэтгэж ажлын хэсэг болон хийдийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулсан.

Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн дэргэд шинээр байгуулах музейн үндсэн чиглэлийг 2013 оны 3 дугаар сард Соёл, спорт, аялал жуулчлалын яаманд өргөн барьсан болно.

4.7 Улс, аймгийн музейгээс түүх, соёлын Хосгүй үнэт болон Үнэт зэрэглэлд хамруулахад бэлтгэн, зохион байгуулан ажилласан талаар:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5-р зүйлд заасны дагуу дурсгалуудыг зэрэглэлд хамруулах тухай дурсгалын танилцуулгыг бэлтгэн Соёл, спорт, аялал жуулчлалын яаманд хүлээлгэн өгсөн. Энэ удаагийн зэрэглэлд хамруулах ажилд улсын чанартай музей төдийгүй хөдөө орон нутгийн музейнүүдийг хамрууллаа. Улсын болон аймгийн музейнүүдээс зэрэглэлд хамруулахаар санал болгосон 63 үзмэрийн танилцуулга жагсаалтыг Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай хамтран бэлтгэж, яамны дэргэдэх Мэргэлжийн зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлсэн болно.

4.8 Говьсүмбэр аймаг дахь “Зараагийн зүүн өврийн хүн чулуу”-ны дэргэд танилцуулга чулуун самбар байрлуулах, хүн чулууг 3 хэмжээстээр баримтжуулах, хажуулдан унах дөхсөн хүн чулууг босгох ажил

Говьсүмбэр аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжийн дагуу Соёлын өвийн төвийн захирал, Говьсүмбэр аймгийн Боржигоны өв музейн захирал нарын байгуулсан гэрээнд тусгагдсан Зараагийн зүүн өврийн хүн чулууны дэргэд чулуун танилцуулга самбар байрлуулах, хүн чулууг 3 хэмжээстээр баримтжуулах, хажуулдан унах дөхсөн хүн чулууг босгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх зорилгоор Соёлын өвийн төвийн менежер Б.Бундхорол, Соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, мэргэжилтэн Д.Нямдорж, Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн програмист Б.Алтансүх, туслах програмист Ж.Даваацэрэн нар 2013 оны 6 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд Говьсүмбэр аймагт томилолтоор ажиллав.

Говьсүмбэр аймгийн төвөөс зүүн хойд зүгт 30 км орших Зараагийн зүүн өврийн хүн чулууны гадуур нарны гэрэл, салхинаас хамгаалах асар барьж, 3 хэмжээстээр баримтжуулах ажлыг хийсэн.

Улаанбаатар хотоос ачсан өргөгч крантай машинаар ачиж ирсэн “Танилцуулга чулуун самбар”-ыг уг хүн чулуунаас баруун урд зүгт 20-30 метр орчимд байрлуулав.

Хүн чулууг босгох нүхийг ухаж босгоход бэлдсэн бөгөөд хүн чулууны улны шороог авч гарган хүн чулуунд хэмжилт хийхэд 3 метр 90 см урттай байлаа. Зараагийн зүүн өврийн хүн чулуу олон жил налуу байсны улмаас дундуураа цууралт өгсөн байсан тул хугарахаас сэргийлж 4 талаар нь мод хийн гадуур нь олсоор бэхэлж өргөгч машинаар өргөв. Суурилуулахдаа хашлагын 2 хавтангаар баримжаа аван, мөн урд зүгт харагдах уулын орой харуулан байрлуулав. Хүн чулууны хажуугаар Улаанбаатар хотоос олж ирсэн суурь чулуунуудаар түгжээ хийж, байгалийн чулуу шороогоор нь чигжиж босгов. Газрын гүнд 1 метр 40 см орчим булсан тул газар дээр 2 метр 50 см орчим ил гарав. Энэ нь хүн чулууны хуучин байсан оромтой тохирч байв. Мөн хүн чулууны суурийг ухаж буй үед хүн чулууны толгойн хэсэг эмтэрхий гарч ирсэн болно.

Уг ажлыг хийж гүйцэтгэсний дараа Боржигоны өв музейн захирал М.Бадамгарав болон Зараагийн зүүн өвөрт нутаглаж буй хот айлын (Шүрэнчулууныхан, Батчулууныхан) хүмүүст хүн чулууг хүлээлгэн өгсөн болно.

4.9 “Бүс нутагт төрөлжсөн музейг хөгжүүлэх нь Дорнод аймгийн жишээн дээр”, “БНХАУ-ын хязгаар бүс нутагт соёлын өвийг хамгаалах ажлын туршлагаас судлах нь” сэдвийн дор зохион байгуулсан туршлага солилцох ажлын талаар

Монгол улсын Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2013 оны А/146 тоот тушаалын дагуу Соёлын өвийн төв нь Дорнод аймгийн музей, Монголын Үндэсний музейтэй хамтран “Бүс нутагт төрөлжсөн музейг хөгжүүлэх нь Дорнод аймгийн жишээн дээр”, “БНХАУ-ын хязгаар бүс нутагт соёлын өвийг хамгаалах ажлын туршлагаас судлах нь” сэдвийн дор Монгол улсын Дорнод аймгийн музейд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Хөлөнбуйр аймгийн Хайлаар, Манжуур хот, Шинэ барга хошууны Алтан эмээл, Шинэ Барга зүүн хошууны Амгаланбаатар хотуудаар явж "Барга" музей /Шинэ баруун барга хошууны/, "Жалай нуурын музей", "Цэргийн бэхлэлтийн музей", "Хуучин барга хошууны угсаатны зүйн музей", "Хайлаарын Үндэсний музей", "Эвенк үндэстний музей", "Хөлөн буйр хотын Монгол эмнэлгийн музей", "Номун ханы" /зүүн барга хошууны/ музей гэсэн 8 музей үзэж танилцсан. Манжуур хотод Соёлын товчоо, мөн аймгийн болон мужийн дэсийн музейн удирдлагуудтай уулзалт, Хайлаар хотод “Хятад-Монголын музейн системийн хилийн газар орны соёлын өвийг хамгаалах суудлын хурал”-д тус бүр оролцсон.

Энэхүү ажилд улс, аймгийн 27 музейн 35 удирдах ажилтан оролцсон ба Монголын музейн тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх тухай саналаа нэгтгэн зөвлөмж хэлбэрээр Соёл, спорт, аялал жуулчлалы яаманд нэгдсэн тайлангийн хамт хүргүүлээд байна.

4.10 Монголын музейн тогтвортой хөгжлийн чадавх дээшлүүлэх төслийн хүрээнд “Үндэсний сургагч бэлтгэх” сургалт

ЮНЕСКО, Японы Итгэлцлийн сангийн тэтгэлгээр Монголын музейн тогтвортой хөгжлийн чадавх дээшлүүлэх төслийн хүрээнд “Үндэсний сургагч бэлтгэх” цуврал сургалтанд тус төвөөс мэргэжилтэн Ш.Энхтуяа хамрагдлаа. Анхны сургалт нь 2013 оны 6 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд Монголын үндэсний музей дээр “Музейн менежмент” сэдэвтэй болж олон улсын сургагч багш док. Юлия Купина хичээл заав. Дараагийн сургалд мөн тус музей дээр оны 6 дугаар сарын 20-24-ны өдрүүдэд “Музейн маркетинг, боловсрол, олон нийтийн харилцаа” сэдвээр олон улсын сургагч багш Паал Морк хичээл заасан байна.

4.11 Шинжээчээр ажилласан тухай

2013 оны 6 дугаар сард АТГ-ын захирамжийн дагуу 1995 онд АНУ-д гарсан үзэсгэлэнд оролцсон нэр бүхий музейнүүдийн 115 ширхэг үзмэр хуулбарлагдсан эсэх, бүрэн бүтэн байдалд хэлтсийн дарга Д.Нарантуяа нь бурханч лам Г.Пүрэвбат, хэл шинжлэлийн хүрээлэнгийн э/ш ажилтан, др Д.Отгонбаатар нарын хамт шинжээчээр ажиллан, 2013 оны 7-р сард зохих дүгнэлтийг гарган АТГазарт хүлээлгэн өгсөн болно.

4.12 Бүлээний овооны гэрэлт хөшөөний бичээсийг 3-н хэмжээстээр баримтжуулах ажил

Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутгаас Кидан бичигт гэрэлт хөшөөг нээн илрүүлсэн бөгөөд өдгөө Монголын үндэсний музейд хадгалагдаж байна. Энэхүү хөшөөн дээрх Кидан их бичгийг 3-н хэмжээстээр скан хийж баримтжуулах ажлыг Японы талтай хамтран 2013 оны 4-р сарын 30-наас 5-р сарын 2-ны хооронд ажилттай хийлээ.

Энэхүү хэмжилтийн ажлыг Япон улсын мэргэжилтэн Ямагучи Хироши удирдан явуулсан бөгөөд Соёлын өвийн төвийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах ажлыг давхар хийсэн юм. Хэмжилтийн ажлыг Японы улсын Засгийн газрын соёлын буцалтгүй тусламжийн хүрээнд Соёлын өвийн төвд хүлээлгэн өгсөн 3-н хэмжээст хэмжилт хийх зориулалт бүхий Vivid 9i төхөөрөмжөөр хийж гүйцэтгэв.

3-н хэмжээст баримтжуулалтын ажлын багт Монгол талаас тус төвийн програмист Б.Алтансүх, техникийн ажилтан П.Чинбат, туслах програмист Ж.Даваацэрэн, Япон талаас Отани их сургуулийн профессор Мацүкава Такаши, 3-н хэмжээст хэмжилтийн мэргэжилтэн Ямагучи Хироши, орчуулагч Нацүки Шимизү нар ажиллав.

4.13 Чойрын хүн чулууг 3-н хэмжээстээр сканнердах ажил

Говьбүмбэр аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжийн дагуу Соёлын өвийн төвийн захирал, Говьсүмбэр аймгийн Боржигоны өв музейн захирал нарын байгуулсан гэрээнд тусгагдсан Монголын үндэсний музейд хадгалагдаж байгаа Чойрын хүн чулууг 3-н хэмжээстээр сканнердах ажлыг 2013 оны 6-р сарын 10-11-ний хооронд амжилттай зохион байгууллаа.

Уг ажлыг тус төвийн програмист Б.Алтансүх ахлан, техникийн ажилтан П.Чинбат, туслах програмист Ж.Даваацэрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажилд Artec Eva 3d болон Vivid 9i 3-н хэмжээст сканнерийг ашиглав.

4.14 Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутаг дахь Хадны зургийг 3D-ээр баримтжуулах ажил

Баян Айраг Эксплорэйшн ХХК-ны 13409А ашиглалтын лизенц бүхий төслийн талбай дахь нүүлгэн шилжүүлэхээр шийдвэрлэгдсэн хадны зургийг анхны байдлаар нь 3D-ээр баримтжуулах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг 2013 оны 7-9-р сард хийж гүйцэтгэлээ. Нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг тус төвийн Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, сэргээн засварлагч Д.Нямдорж нар, 3D лазер хэмжилтийн ажлыг програмист Б.Алтансүх, туслах програмист Ж.Даваацэрэн нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэлээ. Лазер хэмжилтийн хэрэглэгдэхүүнийг ашиглан 3D модель боловсруулах ажлыг мэдээллийн технологийн “Урансофт” ХХК-тай гэрээ байгуулан хийлгэв.

4.15 Шороон бумбагарын бунханта булшны 3D баримтжуулалтын ажил

Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Шороон бумбагарын бунханта булшийг 3D-ээр баримтжуулах ажлыг тус төвийн програмист Б.Алтансүх, туслах програмист Ж.Даваацэрэн, Японы судлаач Ямагучи Хироши, Абей Рай болон Хархорум музейн ажилтнуудаас бүрдсэн баг 2013 оны 8-р сард амжилттай хийж гүйцэтгэлээ. 3D лазер хэмжилтийн ажилд FARO FOCUS 3D лазер сканнер ашигласан. Энэхүү лазер сканнер нь томоохон хэмжээтэй объектийг лазераар хэмжин загварчлах зориулалттай хамгийн сүүлийн үеийн төхөөрмж бөгөөд энэхүү ажлыг Японы судлаач Ямагучи Хироши удирдан зохион байгуулж тус төвийн мэргэжилтнүүдэд уг төхөөрөмж дээр ажиллах дадлага ажлыг давхар хийснээрээ ач холбогдолтой юм.

4.16 Шороон бумбагарын бунханта булшны ханын зургийн фото баримтжуулалтын ажил

Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Шороон бумбагарын бунханта булшны ханын зургийг мэргэжлийн түвшинд авч баримтжуулах ажлыг Өвөрхангай аймгийн Хажорин сумын нутагт орших Хархоурм музейтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж “Урансофт” ХХК-тай хамтран хийж гүйцэтгэлээ. Бунхны ханын зураг жилээс жилд бүдгэрч муудаж байгаа учир өндөр чанартайгаар мэргэжлийн түвшинд фото баримтжуулалтын ажлыг зайлшгүй хийх шаардлагатай байв. Гэрэл зургийг

“Урансофт” ХХК-ны урилгаар Япон улсын иргэн, “Алтан гадас” одонт гэрэл зурагчин Тэрүзоү Сүгияам авлаа. Энэ ажлын хүрээнд 15.6 GB хэмжээ бүхий 198 нэгж өндөр нарийвчлал, чанар бүхий гэрэл зургийн сан бүрдүүлж СӨУНБМСанд хадгаллаа.

4.17 Элст хөтөлийн хадны зургийг 3-н хэмжээстээр бүртгэн баримтжуулах

Төв аймгийн Лүн сумын нутаг Хангай уулын Элст хөтөлийн хадны зургийг 2013 оны 10 дугаар сарын 5-6-ны хооронд 3D скан хийх болон дардас авсан. Энэ ажилд үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа, Т.Эрдэнэцогт, програмист Б.Алтансүх, Ж.Даваасүрэн, техник хариуцсан ажилтан Ч.Чинбат ажилласан. Уг дурсгалын авсан 3-н хэмжээст зураг болон дардасыг УНБМСанд архивлан хадгалав.

4.18 Соёлын өвийн мэдээллийг нээлттэй хүлээн авах дөрвөн сарын аяны хүрээнд www.mongoluv.mn веб сайт боловсруулах, мэдээлэл хүлээн авах ажил

ССАЖСайдын санаачлагаар өрнөж буй Соёлын өвийн мэдээллийг нээлттэй хүлээн авах дөрвөн сарын аяны хүрээнд Биет бус соёлын өв, Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, болон Соёлын баримтат өвийн тухай дэлгэрэнгүй танилцуулга бүхий веб сайт боловсруулж www.mongoluv.mn домайнд байрлуулан ажиллуулж байна. Уг веб сайт соёлын өвийн тухай үндсэн ойлголтууд, телевизийн нэвтрүүлгүүд болон мэдээлэл нээлттэй хүлээн авах форм зэрэг агуулгуудтай.

Веб сайтаар дамжуулан нээлттэй хүлээн авсан өвийн тоо одоогийн байдлаар:

- Соёлын биет бус өвийн төрөл зүйл – 35
- Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч – 44
- Үл хөдлөх дурсгал – 49
- Соёлын баримтат өв – 14 дурсгал тус тус бүртгэгджээ.

Утсаар болон биечлэн 95 иргэн Соёлын өвийн төвд хандан:

- Үл хөдлөх дурсгалын талаар - 34,
- Биет бус өвийн талаар 45,
- Баримтат өвийн талаар 22 нийт 96 мэдээлэл өгсөнийг бүртгэж авсан байна.

4.19 “Галын гэмтэлтэй уран зургийн сэргээн засварлалт” төсөл

Монгол Улс дахь АНУ-ын Элчин Сайдын яамны дэргэдэх “Элчин сайдын нэрэмжит сан”-гийн дэмжлэгтэйгээр 2011, 2012 онд хэрэгжүүлж ирсэн “Галын

гэмтэлтэй уран зургийн сэргээн засварлалт” төслийг 2013 оны 2 дугаар улиралд бүрэн хэрэгжүүлж дууслаа.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сэргээн засварласан 24 уран зургийн үзэсгэлэнг 2013 оны 04 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд Монголын Уран зургийн галерейтай хамтран зохион байгуулсан. Үзэсгэлэнгийн нээлтэд Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яамны дэд сайд Түмэнжаргал, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд хатагтай Пайпэр Кэмпбэлл, зарим сэргээн засварлагдсан уран зургийн зураачид болон бусад холбогдох хүмүүс оролцсон.

Үзэсгэлэнгийн үеэр төслийн ерөнхий танилцуулга, сэргээн засварласан уран зургийн мэдээлэл, сэргээн засварлалтын арга техник зэргийг багтаасан танилцуулгыг /12 нүүртэй, 400 ширхэг/ олон нийтэд тараасан.

Мөн төслийн ерөнхий танилцуулга, сэргээн засварласан уран зургийн мэдээлэл, сэргээн засварлалтын арга техник, засварын өмнөх дараах зургийг багтаасан www.art-painting.eheritage.mn вэб сайтыг Монгол, Англи хувилбараар хийж олон нийтэд танилцуулсан.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөгдсөн бүхий л үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.

4.20 “Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо судалгааны төхөөрөмж” төсөл

Тус төвөөс 2008 онд санаачилсан “Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо судалгааны төхөөрөмж” төслийг Япон улсын Засгийн газраас дэмжиж 42,500,000 /дөчин хоёр сая таван зуун мянга/-н иенийн соёлын буцалтгүй тусламж үзүүлэх болсноо мэдэгдсэн. Мөн ондоо хоёр улсын засгийн газар хамтарсан гэрээнд гарын үсэг зурснаар төсөл хэрэгжиж эхэлсэн. 2012 оны 8 дугаар сард тоног төхөөрөмжийг Монголын талд нийлүүлэх компанийг шалгаруулах тендер зарлагдаж, тус тендерт Япон улсын Огава Сэики компани ялалт байгуулсан.

2013 оны 3 дугаар сард Огава Сэики компани дараах 5 нэр, төрлийн тоног төхөөрөмжийг Монгол Улс руу тээвэрлүүлсэн. Үүнд:

1. X-Ray Analytical Microscope - Рентген судалгааны микроскоп
2. Portable 3D Digitizer - 3 хэмжээст гэрэл зураг авах төхөөрөмж

3. Energy Dispersive X-ray Fluorescence (Handheld type) - Рентген гэрлийн цацрагаар хэмжих багаж
4. Polarizing Analytic Microscope - Гэрлийн микроскоп
5. Fourier Transform Infrared Spectroscopy - Хэт улаан туяагаар задлан шинжлэх төхөөрөмж

Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу гаалийн татвараас бүрэн чөлөөлүүлэх ажлыг тус төвөөс хариуцаж ажилласан. Соёлын өвийг судлах хамгаалах, сэргээн засварлах ажилд шаардлагатай судалгааны FTIR-720, X-Ray analytical microscope-5000, Handheld XMT -7500, Olympus microscope зэрэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулаж ажиллуулах хийж гүйцэтгэсэн.

2013 оны 4 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах сургалт, тоног төхөөрөмж хүлээн авах ажилагааг Огава Сэики компанийн менежер Нобоюүки Мурасэ, Япон улсын Коника Минолта компанийн техникийн ажилтан Такамура Ампо болон Тасуку Ёшимура нар тус төвийн мэргэжилтнүүдэд зохион явуулсан.

2013 оны 6 дугаар сард дээрх тоног төхөөрөмжүүдийг ашиглан Дүрслэх урлагийн музейн үзмэр Өндөр гэгээн Занабазарын Эхийн хөрөг, Өөрийн хөрөг, Гонгор, Доржсэмбэ зэрэг танка зургийн бүтээлүүдэд өнгө будгийн судалгааг хийлээ.

Цаашид төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу тоног төхөөрөмжүүдийг ашиглан түүх, соёлын дурсгалын материал бүтцийг судлах, хээр хөдөө орших үл хөдлөх дурсгалыг 3 хэмжээст байдлаар бүртгэн баримтжуулах ажил графикт хуваариар хийгдэнэ.

4.21 2007-2008 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын актлах, шилжүүлэх үзмэр

2007-2008 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор актлах, шилжүүлэх үзмэрийн жагсаалтыг музей тооллогын салбар комисс гаргаж, актлах үзмэрийг Тооллогийн төв комисс газар дээр нь очиж үзэж танилцан шийдвэрлэж, шилжүүлэх үзмэрийг нэгдсэн журмаар үзэсгэлэн зохион байгуулсан шийдвэрлэж музей бүр дээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын байцаагчийн акт, дүгнэлт гарсан байдаг. Гэвч эцсийн шийдвэр Төрийн өмчийн хорооноос гаргах байсан боловч энэ ажил хийгдээгүй өдий хүрсэн байна. Энэ удаагийн тооллогоор 2007-2008 оны

энэхүү актлах, шилжүүлэх үзмэрийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх шаардлага тулгарч Соёл, спорт аялал жуулчлалны яамны тус төвд үүрэг болгосны дагуу актлах, шилжүүлэх үзмэрийн жагсаалтыг музей бүрээр нь тулгах, excel програмд шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

4.22 Шалгалт

Монголын үндэсний музейд хийгдсэн аудитын шалгалтын дүгнэлтийн дагуу Үндэсний музейн сан хөмрөгийн улсын тооллого, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын байдалтай танилцаж ажлыг 2013-10-18-ноос 22-ны хооронд явуулж ССАЖ-ын Яамны СӨХэлтэст илтгэх хуудсаар танилцуулсан.

4.23 Баримжуулах ажил

ССАЖ-ын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас үүрэг болгосны дагуу Соёлын өвийн төвийн менежер Б.Бундхорол, хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Ш.Энхтуяа нар Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Баянцогт багийн нутаг Тавангийн Ар гэдэг газар байдаг “Баатарын дацан”-ийн туурийн орчимд хууль бусаар малтлагаар гарсан түүх, соёлын дурсгалыг шинжлэх баримтжуулах ажлыг тус суманд очиж ажиллан хууль бус малтлагаас гарсан шашны холбогдолтой 34 нэрийн зүйлийг бүртгэн баримтжуулж, илтгэх хуудсаар явуулсан.

4.24 Байцаагчийн дүгнэлт

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын ажлын хүрээнд Архангай аймгийн музей, Баянхонгор аймгийн музей, Баян-Өлгий аймгийн музей, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн музей, Увс аймгийн музей, Завхан аймгийн музей, Говьсүмбэр аймгийн музей, Дорноговь аймгийн музей, Эрдэнэ-зуу музей, Хархорум музей, Хөшөө цайдам музейд улсын байцаагчийн дүгнэлт гаргалаа.

4.25 Монгол банкны Эрдэнэсийн сангийн улсын тооллогын бүртгэлийг цахим хэлбэрт оруулсан тухай

2012-2013 оны музейн сан хөмрөгийн улсын тооллогын хүрээнд Монгол банкны Эрдэнэсийн сангийн 1108 ERS 0001 “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн дэвтэр”-т нийт **417** дэсийн **1151** ширхэг түүх, соёлын дурсгал тоологдсон ба дэвтэр дээрхи бичилтийг Register програмд шивж оруулах ажлыг 2013 оны 10 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 15-ны хооронд Соёлын өвийн төвийн Соёлын биет өвийг хамгаалах хэлтэс хариуцаж хийсэн. Тоологдсон дурсгалыг төрөл зүйлээр ангилбал:

| № | Төрөл зүйлийн ангилал | Тоологдсон дурсгал | № | Төрөл зүйлийн дэд ангилал | Дурсгалын тоо ширхэг |
|---|---------------------------------|-----------------------|-----|--|-----------------------|
| 1 | Түүхийн холбогдолтой төрөл зүйл | 352 дэсийн 957 ширхэг | 1.1 | Түүхэн бие хүний холбогдолтой зүйл | 7 дэсийн 7 ширхэг |
| | | | 1.2 | Ном хэвлэл, бичгийн холбогдолтой зүйл | 4 дэсийн 4 ширхэг |
| | | | 1.3 | Бэлэг дурсгалын зүйл | 228 дэсийн 789 ширхэг |
| | | | 1.4 | Зоос мөнгөн тэмдэгт | 93 дэсийн 127 ширхэг |
| | | | 1.5 | Бэлгэдэл таних тэмдгийн холбогдолтой зүйл | 14 дэсийн 20 ширхэг |
| | | | 1.6 | Цэрэг байлдааны холбогдолтой зүйл | 5 дэсийн 7 ширхэг |
| 2 | Угсаатны зүй | 26 дэсийн 68 ширхэг | 2.1 | Мал аж ахуй, уналга тээвэр холбогдолтой зүйл | 2 дэсийн 22 ширхэг |
| | | | 2.2 | Дээл хувцас, гоёл чимэглэлийн зүйл | 7 дэсийн 22 ширхэг |
| | | | 2.3 | Гэр зуурын үйлдвэр, гар урлалын зүйл | 17 дэсийн 24 ширхэг |
| 3 | Шашин шүтлэг | 30 дэсийн 43 ширхэг | 3.1 | Цутгамал эд зүйл | 6 дэсийн 6 ширхэг |
| | | | 3.2 | Хөөмөл эд зүйл | 2 дэсийн 2 ширхэг |
| | | | 3.3 | Шашны зан үйлийн холбогдолтой эд зүйл | 21 дэсийн 33 ширхэг |
| | | | 3.4 | Хөгжмийн зэмсэг | 1 дэсийн 2 ширхэг |
| 4 | Археологийн дурсгал | 5 дэсийн 74 ширхэг | 4.1 | Гоёл чимэглэлийн эд зүйл | 4 дэсийн 73 ширхэг |
| | | | 4.2 | Ахуй хэрэглээний эд зүйл | 1 дэсийн 1 ширхэг |

| | | | | | |
|---|-------------------|--|-----|---------------|-------------------|
| 5 | Байгалийн дурсгал | | 5.1 | Үнэт чулуулаг | 4 дэсийн 9 ширхэг |
|---|-------------------|--|-----|---------------|-------------------|

Register програмд бүртгэлийг шивж оруулахдаа үзмэр тус бүр дээр буюу нийт 323 нэгж үзмэрийн гэрэл зургийг /нэгж гэрэл зургийн хэмжээ 3629x2419 pixel, нийт 1570 кадр, 5.33GB/ оруулсан болно.

4.26 Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй биет бус соёлын өвийн хэлтсээс хийгдсэн ажлууд

1.“Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”-д нэр дэвшүүлсэн “Монгол уран бичлэг” СББӨ-ийн төлөөллийн бүртгэлд нэр дэвшүүлсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” номинацийг шинэчлэн сайжруулж, фото зураг, видео материалд нэмэлт оруулснаар 2013 оны 12 дугаар сарын 2-ноос 7-нд Азербайджан улсын Баку хотноо болсон ЮНЕСКО-гийн СББӨ-ийг хамгаалах конвенцийн гишүүн орнуудын Засгийн газар хоорондын 8 дугаар чуулганаар “Монгол уран бичлэг” Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалтад, “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” Хүн төрөлхтний СББӨ-ийн төлөөллийн жагсаалтад тус тус бүртгэгдэв. “Монгол Уран бичлэг”г ЮНЕСКО-гоос тавьсан 5 шалгуурыг бүрэн хангасан үзүүлэлтээр 12 орны ирүүлсэн номинациас тэнцсэн 2 өвийн нэг болж, “Монгол гэрийн урлал, зан үйл 31 орны ирүүлсэн номинациас тэнцсэн 25 илэрхийллийн нэг болж тус тус батлагдсан болно.

2.Мөн 2014 онд ЮНЕСКО-гийн СББӨ-ийн хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад давтан нэр дэвшүүлж буй “Монгол шагайн харваа” номинацийн тодорхойлолт, баримтат кинонд 60-70 хувийн засвар өөрчлөлт хийж ЮНЕСКО-д илгээв.

3. Үндэстэн ястнуудын язгуур бийчдийн төлөөлөл болох АЖ Р.Самжид, СТА М.Дарьсүрэн, Г.Лхагва, Ш.Отгонбаяр, Х.Чулуун, Т.Орших, Ч.Цэсмаа нарын “Язгуурын 7 бурхан” тоглолт Уртын дууч М.Дорждагвын “Монгол төрийн уртын дуу” бүтээлийг Төрийн түүхийн музейд залах ёслоль “Хууртай мөнхрөх аялгуу” нийслэлийн уртын дуучдын уралдааныг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж сан хөмрөгт авав.

4.СББӨ-ийн мэдээллийг олон нийтээс авах аяны хүрээнд СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн маягтыг боловсруулан аймаг орон нутагт явуулав.

5.“ЮНЕСКО-гийн Соёлын өвийн жагсаалт болон Монгол улсын соёлын өвийн үндэсний бүртгэлд орсон болон шинээр нэмж бүртгэх өвийн саналыг хүлээж авах, бүртгэх сурталчлах, олон нийтэд хэлэлцүүлэх тухай” ССАЖ-ын сайдын 2013 оны 8 дугаар сарын 14-ны А/296 дугаар тушаалын дагуу энэ сэдвээр МҮОНТ, Ийгле, UBS, PPD гэх мэт телевизүүд, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Ардчилал” гэх мэт өдөр тутмын хэвлэлүүдэд ярилцлага, мэдээлэл өгсөв. Энэ аяны хүрээнд өвлөн уламжлагчдаас биеэр болон утсаар мөн online-аар мэдээлэл авч байгаа бөгөөд одоогийн байдлаар СББӨ-ийн төрөл зүйлээр 40 хүн бүртгүүлээд байна.

6.Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран Улаанбаатар хотын 9 дүүрэг, 128 хорооны нийгмийн ажилтан, соёлын мэргэжилтнүүдэд СББӨ, түүний өвлөгчийг тогтоох, бүртгэл явуулах, олон нийтээс мэдээлэл хүлээн авах, олон нийтэд хэлэлцүүлэг явуулах, сурталчлах арга зүйн асуудлаар сургалт, семинарийг 2013 оны 12 дугаар сарын 2-нд зохион байгуулав.

4.27. Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтын арга зүйн сургалт

2013 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Соёлын өвийг судлах хамгаалах, сэргээн засварлах ажилд шаардлагатай судалгааны FTIR-720, X-Ray analytical microscope-5000, Handheld XMT -7500, Olympus microscope зэрэг тоног төхөөрөмүүдийг суурилуулаж ажиллуулах сургалтыг Огава Сэики компанийн менежер Нобоюүки Мурасэ, Япон улсын Коника Минолта компанийн техникийн ажилтан Такамура Ампо болон Тасуку Ёошимура нар тус төвийн мэргэжилтнүүдэд зохион явуулсан.

Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн арга зүйн сургалтын ажлын хүрээнд 2013 оны 10-р сарын 14-нөөс 19 –ний хооронд Герман улсын Гёте-Институт, Ионгол дахь Юнесско-гийн төвтэй хамтарсан “Даавуу болон цаасан баримтыг хадгалан хамгаалж сэргээн засварлах нь” - сургалт семинарт тус төвийн сэргээн засварлагч О. Оюунчимэг Б. Мягмарсүрэн нар оролцсон.

2013 оны 11-р сарын 13-наас 16-ний хооронд Чех улсын үндэсний номын сангаас зохион байгуулсан “Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалт, сэлбэн засалт” сургалтанд тус төвийн сэргээн засварлагч О. Оюунчимэг Б. Мягмарсүрэн нар оролцов.

ТАЙЛАН БИЧСЭН:

СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН ЗАХИРАЛ

Г. ЭНХБАТ

СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. НАРАНТУЯА

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

С. ЮНДЭНБАТ

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ

ХЭЛТСИЙН ДАРГА

С. ЧИНЗОРИГ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН МЕНЕЖЕР

Б.БУНДХОРОЛ

2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

-х-